



БАГШ, ЭЦЭГ ЭХИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА БА СУРАЛЦАГЧИЙН АМЖИЛТЫН ХАМААРЛЫН СУДАЛГААНЫ ЗАРИМ ҮР ДҮН (Монгол улс ба БНХАУ -ын ӨМӨЗО -ны ЕБС -ийн жишээн дээр)

Содном Батхуяг^а, CHANG QING^б^аМУБИС-Багшийн сургууль, багш, доктор;^бӨвөр Монголын Багшийн их сургууль,

Залуучуудын улс төрийн дээд сургууль; БНХАУ, ӨМӨЗО, Хөх хот

Холбоо барих зохиогч: batkhuyag@msue.edu.mn 

Хүлээн авсан: 2024.08.25

Хянагдсан: 2024.09.20

Зөвшөөрсөн: 2024.10.25

Хураангуй

Мэдээлэл харилцааны үсрэнгүй хөгжлийн өнөө үед багш, эцэг эхийн хамтын ажиллагааг хэрхэн сайжруулах, суралцагчдын хөгжил, төлөвшилд хэрхэн нөлөөлж буй болон ямар ямар сорилтуудтай тулгарч буйг дэлхийн улс орны эрдэмтэн судлаачид сонирхон судалж байна. Бид энэ судалгаандаа багш, эцэг эхийн хамтын ажиллагаа ба сурагчдын сурлагын амжилтын хамаарлыг авч үзсэн. Монгол улс ба БНХАУ -ын ӨМӨЗО -ны ЕБС -ийн 538 багш нар хамрагдсан. Багш, эцэг эхийн хамтын ажиллагааны түвшин, сурагчид анги дэвших, математик, байгалийн ухааны хичээл, монголын хэлний хичээлийн дүн зэрэг сурагчдын сурлагын амжилтад шууд нөлөөлж байгаа нь харагдсан.

Түлхүүр үг

Хамтын ажиллагаа, сурлагын амжилт, хамаарал

Удиртгал

Багш, эцэг эхийн харилцаа, хамтын ажиллагаа нь суралцагчдын сурлагын амжилт, хүмүүжил, төлөвшилд нөлөөлөх хүчин зүйлсийн нэг бөгөөд өнөөгийн техник, технологийн үсрэнгүй хөгжлийн үед дэлхийн өндөр хөгжилтэй улс орнуудад багш, эцэг эхийн хамтын ажиллагаанд ач холбогдол өгч, энэ чиглэлийн судалгааг хийж байна. Тухайлбал багш, эцэг эхийн эерэг харилцаа, хамтын ажиллагаа нь хүүхдийн хөгжил, боловсролд чухал үүрэг гүйцэтгэдэг гэдгийг хүлээн зөвшөөрдөг (Sanders, M. G., Sheldon, 2009). Амжилттай суралцаж буй сурагчид эцэг эхээсээ хүчтэй дэмжлэг үзүүлдэг болохыг судалгаагаар нотолсон. Цаашилбал, сурагчдын сурч, амжилтад хүрч буй үр дүнтэй сургуулиудын талаарх судалгаагаар эдгээр сургуулиуд нийгэм, эдийн засгийн тааруухан дүүрэгт ажилладаг хэдий ч сургууль, гэр бүлийн хүчтэй,

ээрэг харилцаа, хамтын ажиллагаатай байдгийг харуулж байна (Sanders & Sheldon, 2009; Sheldon, 2009). Энэ нь багш, эцэг эхийн хамтын ажиллагааг суралцагч бага ангид орохоос эхлүүлж, сургуульд суралцах бүхий л хугацаанд үргэлжлүүлэх нь сурагчдын зан үйл, сурлагын амжилтад эергээр нөлөөлдөг болохыг харуулж байна. Сурагчдын хөгжил, төлөвшилд эцэг эхийн нөлөө нь их бөгөөд эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх, сургуулийн талаарх эерэг хандлагыг бий болгохоос эхэлдэг. АНУ-ын Жон Хопкинсийн их сургуулийн судлаач Epstein бага, дунд, ахлах сургуулийн түвшинд 10 жил (1981-1991) хийсэн цуврал судалгааныхаа үр дүнд эцэг эхийн хамтын ажиллагааны зургаан хүрээг боловсруулжээ (Epstein, 2011). Тэдгээрийг нэрлэвэл:

- 1) Эцэг эхийн асрамж хамгаалал,
- 2) Сургууль-гэр бүлийн харилцаа,
- 3) Эцэг эхийн сайн дурын үйл ажиллагаа,
- 4) Гэрээр хичээл давтуулах,
- 5) Шийдвэр гаргахад эцэг эхийг оролцуулах,
- 6) Олон нийттэй хамтран ажиллах зэрэг юм.

Epstein судалгаанууд нь сурагчдын сурлагын амжилт ахиулахын тулд сургууль, гэр бүл, олон нийтийн хамтын ажиллагааны хөтөлбөрүүдэд анхаарлаа хандуулдаг. Чен Жуан (2012) “Америкийн бага, дунд сургуулиудын эцэг эх, гэр бүлийн хамтын ажиллагааны өөрчлөлтийн судалгаа” сэдэвт докторын судалгааны ажилдаа АНУ-ын гэр бүл, сургуулийн хоорондын харилцаанд дүн шинжилгээ хийж, гэр бүл сургууль, багшийн хамтын ажиллагааг чухал болохыг онцолсон. Сун Юнсяо, Лан Мэй нар (2020) “Гэр бүл ба сургуулийн хамтын ажиллагаа” сэдэвт бүтээлдээ Хятадын гэр бүлийн боловсролын өнөөгийн хөгжлийн онцлог байдлыг судалж, сүүлийн жилүүдэд Хятадын гэр бүлийн боловсролын хөгжлийн үйл явц, өнөөгийн байдал, эцэг эхийн боловсролын үзэл баримтлал, хамтын ажиллагааг авч үзсэн байна. Жан Рунлин (2020) “Сургуулийн, гэр бүлийн боловсролын удирдамж” бүтээлдээ гэр бүл, сургуулийн хамтын ажиллагааны суурийг хэрхэн тавих, бодитоор хэрэгжүүлэх талаар тусгасан. Лу Жүнён, Тао Чин нар (2018) хөдөө орон нутгийн гэр бүл, сургуулийн хамтын ажиллагаа нь хүүхдүүдэд эрүүл мэнд, хувийн аюулгүй байдлын мэдлэг олгох, хүүхдийн гэр бүлийн туршлагыг ойлгох, хүүхдүүдэд шинжлэх ухаанч, ардчилсан үзэл санааг төлөвшүүлэхэд тустай гэж үзсэн байна.

Эцэг эхийн оролцооны зургаан хэлбэрийн хүрээнд сургуулиуд олон төрлийн ажлыг зохион байгуулдаг өөр өөрийн туршлагатай байх нь гарцаагүй. Гэвч эцэг эхийн оролцооны эдгээр хэлбэрт бүгдэд нь сургууль-гэр бүлийн хоёр талт харилцаа нэн чухал билээ (Батдулам, С. 2021, х. 18).

Өрнөдийн судлаач Nguon 2012 онд Камбож улсад хийсэн эцэг эхийн оролцооны талаарх судалгааны үр дүнд эцэг эхийн оролцооны гурван хэлбэрийг тодорхойлон гаргажээ. Энэ нь:

1. Сургуулийн орчин дахь оролцоо,
2. Гэр бүлийн орчин дахь оролцоо,
3. Эцэг эхийн зүгээс сургуульд оруулж буй хувь нэмэр зэрэг юм. Үүнийг судлаач Сүхбаатар судалгаандаа өргөн тусган ажигласан байдаг.

Багш-эцэг эхийн үр дүнтэй, тогтмол харилцааг дэмжихэд эцэг эхчүүдэд чиглэсэн үйл ажиллагаа чухал. Хот, хөдөөгийн сургуулийн 500 гаруй багш, сургалтын менежерийг хамруулсан нэгэн судалгааны “Сургалтын үйл ажиллагаанд эцэг эхийг оролцуулан тогтмол зохион байгуулдаг үр дүнтэй ажлуудаас нэрлэнэ үү?” гэсэн асуултад оролцогчид дараах байдлаар хариулжээ (Сосорбарам, 2013). Судалгаанд оролцогчдын бичсэн ажлуудыг давтамжийн дарааллаар нь авч үзэхэд:

- (а) эцэг эхийн хурал;
- (б) эцэг эхийн нээлттэй өдөр;
- (в) анги танхим тохижуулах ажил;
- (г) сурган хүмүүжүүлэх сургалт семинар;
- (д) тайлант уншлага;
- (е) биеийн тамирын болон бусад уралдаан тэмцээн;
- (с) эрдмийн баяр зэрэг байв.

Гэвч эдгээр үйл ажиллагааг судлаач Л.Сосорбарам үр өгөөж багатай, шинэлэг бус гэж үзээд, багш, эцэг эхийг бие биеэ ойлгож хүндэтгэх, дэмжихэд чиглэсэн байдал хангалтгүй хэмээн дүгнэжээ (Сосорбарам, Л. 2013).

Гэр бүлийн орчны сурах нөөц, сургуульд бэлтгэгдсэн байдал (Монгол, Өвөр Монгол Хүүхдийг Харьцуулж Судалсан нь. Ж.Орчлон, Бага насны хүүхдэд флашкартын аргаар нэвтэрхий толины мэдлэг олгоход эцэг эхийг дэмжих тухай Б.Ариунтуул, Б.Нямжав нар, “Багш эцэг эхийн хамтын ажиллагаа ба сурагчийн суралцахуйн харилцаа хамаарлын судалгаа” Б.Лхамноржмаа гэх мэт Монгол улсад олон арван судлаачдын эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээл байна. Хэдийгээр багш, эцэг эхийн харилцаа, хамтын ажиллагааг дотоод, гадаадын олон эрдэмтэн судлаачид судалж байгаа боловч багш, эцэг эхийн харилцаа, хамтын ажиллагаа нь сурагчдын боловсролд үр дүнтэй байдаг эсэх талаар санаа зовоосон асуудал байсаар байна. Багш нар, эцэг эхийн харилцаа, хамтын ажиллагааны үр дүнтэй туршлага, боловсролын үйл явцад хувь нэмэр оруулах арга замын талаар өөр өөр санал бодолтой байж болно.


Иймээс суралцагчдын сурлагын амжилтыг дээшлүүлэх, хүмүүжил, төлөвшилд багш эцэг эхийн харилцаа, хамтын ажиллагаанд нөлөөлөх хүчин зүйлсийг судлан тодорхойлоход оршиж байдаг. Иймээс бид энэ талбараас “Багш, эцэг эхийн хамтын ажиллагааг” сонгон өөрийн судалгааны ажлыг түүнд чиглүүлсэн болно.

Судалгааны арга зүй

Багш, эцэг эхийн хамтын ажиллагааг тодорхойлох асуулгыг google forum болон 问卷星 (wen Juan xing) ашиглан Монгол улс, Хятадын ӨМӨЗО -ны багш нараас судалгаа авч нэгтгэн дүгнэв.

Судалгааны үр дүн

Судалгаанд 2023-2024 оны хичээлийн жилд Монгол улсын 269 багш, Хятадын ӨМӨЗО -ны 269 багш нараас багш, эцэг эхийн хамтын ажиллагааг тодорхойлж, үр дүнг тооцов.



Судалгаанд 21 -56 насны багш хамрагдсан ба 21-26 насныхан 10.97 хувь, 27-32 насныхан 16.54%, 33-38 насныхан 20.07%, 39-44 насныхан 20.63%, 45-50 насныхан 18.77%, 51-55 насныхан 10.4%, 56 дээш насныхан 2.6 %-ийг эзэлж байна. Эрэгтэй 13.01%, эмэгтэй 86.99% байв. 1-ээс 21 -ээс дээш жил ажилласан багш нар хамрагдсан. Энэ нь судалгаанд ажлын туршлагаар бүх төлөөлөл хамрагдсаныг илтгэж байна. Та өөрийн ангийн багш, эцэг эхийн хамтын ажиллагааны түвшнийг 1-5 оноогоор үнэлсэн байдал.

Хүснэгт 1. Багш, эцэг эхийн хамтын ажиллагааны түвшнийг 1-5 оноогоор үнэлсэн байдал.

Улс	Сул	Сулавтар	Дунд зэрэг	Сайн	Маш сайн
Монгол улс	3	15	79	109	63
Хятадын ӨМӨЗО	6	28	95	81	59
Нийлбэр	9	43	174	190	122
Хувь	2 %	11 %	43 %	47 %	30%

Дээрх хүснэгтээс үзэхэд судалгаанд хамрагдсан хоёр улсын багш нар эцэг, эхтэй хамтын ажиллагааны түвшнийгээ 30 % нь маш сайн, 47 % нь сайн, 43 % нь дунд зэрэг, 11 % нь сулавтар, 2 % нь муу гэж үнэлсэн байна.

Багш, эцэг эхийн хамтын ажиллагаа нь анги дэвших болон математик, байгалийн ухаан, монгол хэлний хичээлийн дүнгүүдтэй хэрхэн хамааралтай буйг судалж, дараах хүснэгт нэгтгэж харуулав.

Хүснэгт 2. Багш, эцэг эхийн хамтын ажиллагаа ба сурлагын амжилт

Хамаарал		Анги	Математикийн дүн	Байгалийн ухааны хичээлийн дүн	Монгол хэлний дүн	Хамтын ажиллагаа
Анги	Pearson Correlation	1	-.715**	-.469**	-.479**	-.388**
	Sig. (2-tailed)		.000	.000	.000	.000
	N	600	600	600	600	600
Математикийн дүн	Pearson Correlation	-.715**	1	.532**	.483**	.592**
	Sig. (2-tailed)	.000		.000	.000	.000
	N	600	600	600	600	600
Байгалийн ухааны хичээлийн дүн	Pearson Correlation	-.469**	.532**	1	.847**	.403**
	Sig. (2-tailed)	.000	.000		.000	.000
	N	600	600	600	600	600
Монгол хэлний дүн	Pearson Correlation	-.479**	.483**	.847**	1	.340**
	Sig. (2-tailed)	.000	.000	.000		.000
	N	600	600	600	600	600
Хамтын ажиллагаа	Pearson Correlation	-.388**	.592**	.403**	.340**	1
	Sig. (2-tailed)	.000	.000	.000	.000	
	N	600	600	600	600	600

** . Correlation is significant at the 0.01 level (2-tailed).

Дээрх хүснэгтээс үзэхэд багш, эцэг эхийн хамтын ажиллагаа анги дэвших бүр буурч, математикийн хичээлийн дүнтэй нь хүчтэй сөрөг хамаарал (-0.715**) байна. Энэ нь ангийн түвшин нэмэгдэхийн хэрээр математикийн дүн буурах хандлагатай байгааг харуулж байна. Байгалийн ухааны хичээл (-0.469**), Монгол хэл (-0.479**) дунд зэргийн сөрөг хамааралтай байна.

Дүгнэлт

Ном зүйн тойм судалгааны үр дүнгээс үзэхэд сурагчдын сурлагын амжилтад нөлөөлдөг чухал хүчин зүйлийн нэг нь багш, эцэг эхийн хамтын ажиллагаа болох нь тодорхой харагдаж байна.

Судалгаанд хамрагдсан хоёр улсын багш нар эцэг, эхтэй хамтын ажиллагааны түвшнийгээ 30 % нь маш сайн, 47 % нь сайн, 43 % нь дунд зэрэг, 11 % нь сулавтар, 2 % нь муу гэж үнэлсэн байна (хүснэгт 1).

Анги дэвших тусам нь багш, эцэг эхийн хамтын ажиллагаа суларч сурагчдын сурлагын амжилт буурч байгааг харуулж байна (хүснэгт 2). Энэ нь багш, эцэг эхийн хамтын ажиллагаа нь сурагчдын сурлагын амжилтад шууд нөлөөлдөг болохыг илтгэж байна. Иймээс эцэг, эх, асран хамгаалагчид хүүхдийнхээ багш нартай нягт хамтран ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.

Ном зүй

Epstein, J. (2009). In School, family, and community partnerships: Your handbook for action. USA: Corwin Press.

Sanders, M. G., & Sheldon, S. B. (Eds.). (2009). Principals matter: A guide to school, family, and community partnerships. Corwin Press.

Батдулам, С. (2021). Сугууль- Гэр бүлийн харилцаа ба багш боловсрол. Улаанбаатар: 18.

Сосорбарам, Л. (2013). Сурагчдын төлөвшилд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх боломжийг судалсан нь. Улаанбаатар.

Сун Линлин, С. Б. (2018). Сурагчдын сурах арга барилд гэр бүл сургуулийн хамтын ажиллагаа нөлөөлөх нь. Teaching and Educating people.

Лу Жүнён, Тао Чин. (2018). Хөдөөгийн сургууль ба гэр бүлийн хамтын ажиллагаа. Орчин үеийн боловсролын менежмент, 12-16.

Фэйфэй, Х. (2018). Бага сургуулийн сурагчдын сурлагын гүйцэтгэлд гэр сургуулийн харилцааны төрлүүдийн нөлөө. Боловсролын судалгаа, туршилт.

SOME RESULTS OF THE STUDY ON THE CORRELATION BETWEEN TEACHER-PARENT COOPERATION AND STUDENT ACHIEVEMENT

^aBatkhuyag S, ^bCHANG QING

^aPh.D., Teachers School, MNUE;

^bInner Mongolia Normal University, Youth University for Political Sciences,
China, Inner Mongolia, Hohhot

Corresponding author: batkhuyag@msue.edu.mn 

Abstract

In this era of rapid development in information and communication, researchers and scholars worldwide are studying how to develop cooperation between teachers and parents and the challenges they face. In our research, we examined the relationship between teacher-parent collaboration and student academic achievement. The study involved 538 teachers from general education schools in Mongolia and the Inner Mongolia Autonomous Region of China. It was observed that the level of cooperation between teachers and parents directly affects students' academic performance, including grade progression, mathematics, science, and Mongolian language scores.

Keywords

cooperation, academic achievement, correlation